



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2020 оны 04 сарын 08 өдөр

Дугаар 184

Улаанбаатар хот

「 Албан журмын даатгагчдын холбооны удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 12<sup>1</sup> дугаар зүйлийн 12<sup>1.2</sup> дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Албан журмын даатгагчдын холбооны удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнээс даатгуулагчийн төлөөлөл М.Бизаагундааг чөлөөлсүгэй.
2. Албан журмын даатгагчдын холбооны удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд даатгуулагчийн төлөөллөөр Монголын тээвэр, холбоо, газрын тосны ажилтны үйлдвэрчний эвлэлийн холбооны дарга Б.Рагчааг баталсугай.
3. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 433 дугаар тогтоолын хавсралтад заасан М.Бизаагундаад холбогдох хэсгийг хүчингүй болгосугай.
4. Даатгалын тухай хууль тогтоомжийг чанд мөрдөж, хүлээсэн үүргээ биелүүлж ажиллахыг шинээр батлагдсан гишүүн /Б.Рагчаа/-д үүрэг болгосугай.
5. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН